



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/41


Эрдэнэт

┌ Тэмцээний зардалд хөрөнгө гаргах тухай ┐

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5./а/, 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдааны 01 дүгээр тогтоолын зургаадугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2017 оны 02 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд АНУ-ын Лас Вегас хотноо зохиогдох заалны Дэлхийн цомын 4 дэх удаагийн цуврал Байт харвааны тэмцээнд Орхон аймгийг төлөөлж оролцох “Хангарьд” спорт клубын тамирчин Б.Адьяасүрэн, дасгалжуулагч Т.Цогтбаяр нарын зардалд 2500000 /Хоёр сая таван зуун мянган/ төгрөг, “SPRITE CUP” 15 хүртэлх насны Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг тамирчдын оролцооны төлбөр, замын зардлын 995000 /Есөн зуун ерэн таван мянган/ төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2.Шаардагдах зардал 3495000 /Гурван сая дөрвөн зуун ерэн таван мянган/ төгрөгийг Засаг даргын нөөц сан хуваарилагдаагүй бусад зардлын жагсаалтын “Соёл, спорт, хүүхэд залуучууд, олон нийтийн арга хэмжээг жилийн туршид зохион байгуулах арга хэмжээний зардлаас гаргахыг Санхүү, Төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Д.БАТЛУТ